



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Засгийн газраас 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” /цаашид “нийтлэг журам” гэх/-д энэ журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2022 онд “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээний, үнэлгээ хийх журам” /цаашид “салбарын журам” гэх/-ыг А/107 дугаар тушаалаар баталж мөрдүүлсэн.

Дээрх баримт бичгүүдийн дагуу Цагдаагийн ерөнхий газраас 2024 онд хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулсан бодлогын баримт бичгийн 6 арга хэмжээний 71 зүйл, заалт, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 64 арга хэмжээний 107 зүйл, заалтын хэрэгжилт, салбарын журмын 3.2.3-т заасан үйл ажиллагааг хамруулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газар 2024 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний ерөнхий оноогоор 4.54 буюу 90.8 хувьтай дүгнэгдсэн байна.

Хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт			Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5	6
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	97.04	56.5	4.54 оноо
	2	Алсын хараа 2050	97.7		
	3	Шинэ сэргэлтийн бодлого	91.8		
	4	Монгол Улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	93.0		
	5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	-		
	6	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	95.0		
	7	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	90.0		
БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	1	Стратеги төлөвлөгөөний биелэлт	88.0	17.7	
	2	Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	96.1		

	3	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	81.3		
БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	1	Ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	83.8	16.7	
	2	Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ	99.2		
	3	Шударга байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	75.8		
	4	Хэрэглэгчийн үнэлгээ	74.4		
Ерөнхий үнэлгээ				90.8	

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР